



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/357

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монголын драмын урлагийн дээд шагнал гардуулах “Гэгээн муза-16” Олон улсын театрын урлагийн наадмын драмын жүжгийн төрөлд “Монгол туургатан” театрын “Шар гэгээ” жүжиг шалгарч, тус наадмын эцсийн шатны шалгаруулалт 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хотод “Улаанбаатар” театрт олон улсын шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулагдах бөгөөд тус арга хэмжээнд шаардагдах төсвийг хавсралт ёсоор баталсугай.

2. Санхүүжилтэд шаардагдах 2,200,000 (хоёр сая хоёр зуун мянган) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), шилэн дансанд байршуулахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт зөвшөөрсүгэй.


3. Олон Улсын уралдаанд оролцох бэлтгэлийг хангуулж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Монгол туургатан театрын захирал (Д.Намсрайноров)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.МӨНХБААТАР



Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар
сарын 22 -ны өдрийн А/357 дугаар
захирамжийн хавсралт



МОНГОЛЫН ДРАМЫН УРЛАГИЙН ДЭЭД ШАГНАЛ ГАРДУУЛАХ
“ГЭГЭЭН МУЗА-16” ОЛОН УЛСЫН ТЕАТРЫН УРЛАГИЙН НААДМЫН ШИЛДГИЙГ
ШАЛГАРУУЛАХ ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСВИЙН
ЗАДАРГАА

Д/Д	Зардлын нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Тайзны түрээсийн үнэ	2	цаг	500,000	1,000,000
2	Жүжгийн тусгай гэрлийн түрээс	8	-	1,200,000	1,200,000
	Нийт				2,200,000

ТӨСӨВ НЭГТГЭСЭН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:

А.ХАЖИДМАА

ТӨСӨВ ХЯНАСАН:

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН

ТӨСВИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:

Ч.ЦЭЦЭГСҮРЭН

